



**ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2017 оны 06 сарын 15 өдөр

Дугаар А/327

Эрдэнэт

Хөрөнгө гаргах тухай


Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэр нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4/б/, 29.2 дахь заалт, Авто тээврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 03 дугаар тогтоолын 1.4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орхон аймгийн хэмжээнд Авто замын тээврийн үйлчилгээг боловсронгуй болгох бодлогын баримт бичгийг боловсруулах, зөвлөх ажил үйлчилгээний ажилд шаардагдах зардлыг нэгдүгээр хавсралт, судалгааны ажлын төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Дээрх зардалд шаардагдах 15.000.000 /Арван таван сая / төгрөгийг Төсөвт хөтөлбөрийн зардлаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

3.Бодлогын баримт бичгийн боловсруулалтыг чанарын өндөр түвшинд боловсруулж хүлээн авах ажлыг зохион байгуулж ажиллахыг Хөрөнгө оруулалт, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс /н.Баяржаргал/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.БАТЛУТ